

# SMM GUIDE: ХӨРӨНГӨ ОРУУЛАХ НЬ



# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ОЙЛГОХ НЬ



**Хөрөнгийн зах зээл (ХЗЗ)** нь компаниудад үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө татах боломжийг олгодгоороо онцлог бөгөөд хувьцаа, бонд зэрэг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн санал болгон санхүүжилт татаж, үйл ажиллагаагаа тэлдэг.

Нөгөө талаас, хөрөнгө оруулагчид тэдгээр хувьцааны өсөлт, бондын хүүнээс өгөөж хүртэх байдлаар өөрийн хөрөнгийг өсгөх боломжтой. Тэгвэл энэ харилцааг бий болгоход Хөрөнгийн бирж хамгийн чухал үүрэгтэй. Хөрөнгийн бирж нь тухайн улсын хамгийн том, нэр хүндтэй, ирээдүйд өсөх боломжтой компаниудыг бүртгэдэг.

Энэ утгаараа ХЗЗ нь иргэдийг өсөх потенциалтай, томоохон компаниудад хөрөнгө оруулж, үр өгөөжийг нь хамтдаа хүртэх боломжийг олгодгоороо давуу талтай.

## Хөрөнгийн Зах Зээлийн оролцогч талууд

### Хөрөнгийн Бирж

Хөрөнгийн бирж гэдэг нь хувьцааны арилжааг зохион байгуулдаг гол талбар бөгөөд энгийнээр тайлбарлавал хувьцаа зардаг дэлгүүр юм.

### Үнэт цаасны компани

Хөрөнгө оруулагч та үнэт цаас худалдах, худалдан авахын тулд заавал ҮЦК-иар дамжуулан захиалгаа өгч арилжаанд оролцоно.

### Бусад

ХЗЗ нь хууль, журмаар зохицуулагдсан бөгөөд мөнгөн хөрөнгийн арилжааг гүйцэтгэхэд “Үнэт цаасны клирингийн төв”, хөрөнгө оруулагчдын бүртгэхэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ажилладаг.

# МОНГОЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ БОЛОМЖУУДЫН ТАЛААР ТАНЫ МЭДЭХ ЁСТОЙ БҮХ ЗҮЙЛС

Монголд 1991 онд хөрөнгийн бирж байгуулагдсанаар хөрөнгийн зах зээл (ХЗЗ) ийн эхлэл тавигдсан. Өдгөө олон нийтэд санал болгож буй нээлттэй бүтээгдэхүүнүүд биржээр, хаалттай буюу мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгодог бүтээгдэхүүнүүд (дийлэнхдээ хаалттай бонд) биржийн бус зах зээл (ББЗЗ)-ээр дамжин арилжаалагдаж байна. Энэхүү дугаарт бид нээлттэй зах зээлийн талаар онцлох болно.

## Монголын ХЗЗ-ийн үнэлгээ сүүлийн 5 жилд 4 дахин өсөв

■ ХЗЗ-ийн үнэлгээ (их наяд төгрөг) ■ ДНБ-д эзлэх ХЗЗ-ийн үнэлгээ



## Монголын Хөрөнгийн Зах Зээл

Зах зээлийн үнэлгээ

₮13 их наяд

Үнэт цаасны компани

+50

Үнэт цаасны данстай иргэдийн тоо

3,039,421

Хамгийн том бирж

Монголын хөрөнгийн бирж (МХБ)

МХБ-ийн өдрийн дундаж хувьцааны арилжааны дүн

₮976.2 сая

Идэвхтэй ХО-чдын тоо

30,404

Эх сурвалж: СЗХ, МХБ, ҮЦТХТ, МҮЦКТ

2025 оны III сарын байдлаар

## Сүүлийн 20 жилийн хугацаанд анхдагч зах зээл дээр 68 гаруй компани хувьцаа болон бондын санхүүжилтээр ₮3.6 их наядыг хөрөнгө оруулагчдаас татжээ.

Анхдагч зах зээл дээр МХБ-ээр татсан хөрөнгийн хэмжээ /Тэрбум төгрөг/

Жил	IPO	FPO	Нээлттэй Бонд	Нээлттэй ХБҮЦ	Нээлттэй ХОС	Нийт
2005-2009	57.1	42.3	2.2	-	-	101.5
2010-2014	3.5	240.7	4.4	-	-	248.6
2015-2019	109.2	107.5	6.5	-	-	223.2
2020-2024	578.0	417.5	1,710.6	259.9	55	3,021.1
Нийт	747.8	808.0	1,723.7	259.9	55	3,594.4

# МХБ ДЭЭРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖУУД



## Хэрхэн худалдаж авах вэ?

Та хөрөнгө оруулагч болохын тулд эхлээд брокерын компанид үнэт цаасны данс нээж, дансаа цэнэглэн захиалга өгөх шаардлагатай. Брокерын компани сонгохдоо хамгийн түрүүнд гар утасны апп болон онлайн арилжааны системтэй эсэхийг нь нягтлаарай. Ингэснээр та цаг алдалгүй хурдан арилжаанд оролцож чадна.


## Арилжаа хэрхэн явагддаг вэ?

Та захиалгаа брокерын компанидаа хэзээ ч өгч болно. ГЭХДЭЭ таны өгсөн захиалга ажлын өдрүүдэд 10:00-13:00 цагийн хооронд л биелэх боломжтой. Энэ хугацаанд та зах зээлийн идэвхийг хянаж, хувьцаа болон бондыг шууд худалдан авах боломжтой.

### ХУВЬЦАА

Та **хувьцаанд** хөрөнгө оруулснаар ханшийн зөрүүнээс ашиг олох болон ногдол ашиг авах байдлаар өгөөж хүртэх боломжтой.

#### Ангилал:



### НЭЭЛТТЭЙ БОНД

**Нээлттэй бондын** хамгийн том давуу тал нь — та тухайн бондыг эзэмшсэн хугацаанд ногдох хүүг тооцуулан мөнгөө өсгөх боломжтой байдаг

Хөрөнгө оруулах  
доод хэмжээ  
₮100,000, \$100

Жилийн хүү  
10-19.2% (MNT), 5.8-10% (USD)

### Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)

**ХБҮЦ** нь бондтой адил тогтмол хүүтэй бүтээгдэхүүн юм. Одоо хөрөнгийн бирж дээр 6 ХБҮЦ идэвхтэй арилжаалагдаж байна.

Хөрөнгө оруулах  
доод хэмжээ  
₮100,000

Жилийн хүү  
18.47%

### БУСАД

Хаалттай бонд нь Биржийн бус зах зээл (ББЗЗ) дээр арилжаалагддаг ба тус төрлийн бондтой холбоотой мэдээллийг авахыг хүсвэл манай сонины өмнөх дугаар болох "СММ GUIDE: M-OTC MARKET"-аас дэлгэрэнгүй уншина уу.



# МОНГОЛЫН ЗАХ ЗЭЭЛД ХУВЬЦААНД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ СТРАТЕГИ

Хувьцаанд хөрөнгө оруулахдаа компаниудын санхүүгийн тайлан, салбарын өсөлтийн боломж, макро эдийн засгийн нөхцөл байдал зэргийг анхаарахаас гадна хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгө оруулалтын стратегийг тодорхойлох нь нэн чухал. Хөрөнгө оруулалтын стратеги гэдэг нь хөрөнгө оруулагч санхүүгийн зорилгодоо хүрэхийн тулд ашигладаг аргачлал ба эрсдэлийн түвшин, хөрөнгө оруулалтын хугацаа, санхүүгийн хэрэгслүүдийн сонголт зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

## Хөрөнгө оруулах боломжтой хувьцааны төрлүүд:

### Өсөлтийн хувьцаа (Growth stock)

Орлого, ашиг нь хурдтай өсөх буй, ногдол ашиг тараадаггүй (маш бага тараадаг) компанийн хувьцаа.

#### 📊 СТРАТЕГИ:

🔍 Өсөлтийн өндөр потенциалтай компанийг сонгох

#### 🕒 Тэвчээртэй байх

#### 📈 Судлах, шинжих чавдар

- Зах зээлийн хэмжээ, өрсөлдөх давуу тал.
- ROE, PE ratio, Debt-to-equity зэрэг үзүүлэлтүүд.

#### 📉 Зах зээлийн хэлбэлзлийг хүлээн зөвшөөрөх

- Түр зуурын уналтаас айлгүй урт хугацааны төлөвийг харж шийдвэр гаргах

#### 📊 Мэдээлэлтэй, шүүмжлэл сэтгэлгээтэй байх

- Компанийн стратеги, өрсөлдөгчид, зах зээлийн эрсдэлийг байнга шинжиж дүгнэх.
- Хэт хөөсөрсөн өндөр үнэлгээнд болгоомжтой хандах.

#### 🗨️ Хэнд тохирох вэ?

- Урт хугацаанд хөрөнгө оруулах төлөвлөгөөтэй залуу хүмүүс.
- Эрсдэл хүлээх чадвартай, өндөр өгөөж хүлээдэг хөрөнгө оруулагч.
- Хуримтлалаа өсгөх, баялаг бий болгох зорилготой.

### BLUE-CHIP

Урт хугацааны туршид ашигтай ажиллаж, ногдол ашиг тогтмол тараадаг, зах зээлдээ тэргүүлэгч компанийн хувьцаа.

#### 📊 СТРАТЕГИ:

🔒 “Buy and Hold” буюу удаан хугацаанд барих

📊 Ногдол ашгийг өгөөжид дахин хөрөнгө оруулах

📊 Дунд хугацаанд үе шаттайгаар худалдаан авах

- Тогтмол хугацаанд (сард 1 удаа гэх мэт) тогтсон мөнгөн дүнгээр худалдаан авах.
- Зах зээлийн хэлбэлзлийг ашиглан үнэ унаж буурахад нэмж худалдаан авч, дундаж бууруулах.

#### 🗨️ Эрсдэлээ тарааж байршуул:

- Зөвхөн нэг blue chip хувьцаанд бус, хэд хэдэн салбарын тогтвортой компаниудад хөрөнгө оруулалт хийж.

#### 🗨️ Хэнд тохирох вэ?

- Урт хугацааны хөрөнгө оруулагч.

### Ногдол ашгийн хувьцаа (Dividend stock)

Хөрөнгө оруулагчдад тогтмол ногдол ашиг өгдөг хувьцаа.

#### 📊 СТРАТЕГИ:

📊 Ногдол ашгийг өгөөж болон ашгийн хэдэн хувиа тарааж байгааг тооцоол.

- Ногдол ашгийн өгөөжийн түвшин = Ногдол ашиг / Хувьцааны үнэ

📊 Ногдол ашгаар дахин хөрөнгө оруулах

- Ногдол ашгаа дахин хөрөнгө оруулах замаар нийлмэл хүүгийн ашиг олох

#### 📉 Зах зээлийн хэлбэлзлийг ашиглах

- Зах зээлийн үнэ ханш нь буурсан ч ногдол ашиг нь хэвээр эсвэл өсч байгаа хувьцааг авч, өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой

#### 📉 Багц бүрдүүлэх

- 2-3 төрлийн ашиг өгдөг ялгаатай салбарын хувьцааг сонгон багцын эрсдэлийг бууруулах

#### 🗨️ Хэнд тохирох вэ?

- Тогтмол пассив орлого хүсдэг буй хөрөнгө оруулагч
- Анхлан суралцагч, тогтвортой өгөөж сонирхогч
- Урьдчилан таамаглалт орлого, тэтгэврийн хөтөлбөрт тохиромжтой

# ТА ХУВЬЦААНЫ ӨГӨӨЖӨӨ ЮУНД АШИГЛАХААР ЗОРЬЖ БАЙНА ВЭ?

Дээрх асуултаас л таны хөрөнгө оруулалтын стратеги тодорхойлогдоно. Хувьцааны өгөөжийг хэрхэн ашиглах буюу таны зорилгоос шалтгаалан хөрөнгө оруулалтын хугацаа, төрөл, эрсдэл-өгөөжийн харьцаа бүхий оновчтой стратеги бүрэлдэх юм. Хөрөнгө оруулалтын зорилго болон хугацааг тодорхойлсны дараагаар хөрөнгө оруулагч та өөрийн эрсдэл даах чадварыг тодорхойлох нь чухал.

## АЛЬ САРД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ НЬ ОНОВЧТОЙ ВЭ?

МХБ-ийн ТОП 20 индексийн сүүлийн 10 жилийн ханшийн дундаж хөдөлгөөн

Сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Өөрчлөлт (дундаж, %)	2.9%	2.3%	1.7%	-2.4%	-1.4%	0.4%	3.0%	1.1%	3.4%	0.3%	0.7%	2.7%

Эх сурвалж: МХБ

### Өсөлттэй сарууд

- **I-III сар** – Ногдол ашгийн хүлээлт нэмэгдэж, зах зээлийн идэвхжил нэмэгддэг.
- **VII сар** – Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, ХК-ууд улирлын тайлангаа нийтэлдэг.
- **XII сар** – Жилийн эцсийн санхүүгийн үзүүлэлтүүд, хөрөнгө оруулалтын шийдвэрүүд, манипуляци зэрэг шалтгаанаар идэвхждэг.

### Бууралттай Сарууд

Түүхэн хэлбэлзлээс үзэхэд IV-V саруудад зах зээл уналттай байдаг нь хэд хэдэн шалтгаантай:

- **Ногдол ашгийн дараах нөлөө:** Хөрөнгө оруулагчид ногдол ашиг хүртэж, хувьцаагаа зарснаар ханш буурдаг.
- **Зах зээлийн тодорхойгүй байдал:** Ногдол ашгийн хэмжээ, хуваарийн талаарх мэдээлэл тодорхойгүй үед арилжааны идэвх буурч, хүлээлтийн сэтгэл зүй давамгайлдаг.
- **Хөрөнгө оруулалтыг хойшлуулах хандлага:** Хөрөнгө оруулагчид VII сар хүртэл санхүүгийн мэдээллийг хүлээж, шинэ хөрөнгө оруулалтаа түр зогсоодог.

## Хувьцаанд хөрөнгө оруулагчдын төрөл

### Эрсдэлд дуртай

ӨСӨЛТИЙН ХУВЬЦАА болон БЛҮ-ЧИП ХУВЬЦАА-нд хөрөнгө оруулах нь тохиромжтой

### Эрсдэлд саармаг

ӨСӨЛТИЙН ХУВЬЦАА болон БЛҮ-ЧИП ХУВЬЦАА ХОСОЛСОН хөрөнгө оруулалт хийх

### Эрсдэлд дургүй

Голчлон НОГДОЛ АШГИЙН ХУВЬЦАА-нд хөрөнгө оруулалт хийх нь элбэг.

## Тэгвэл хэзээ хөрөнгө оруулах вэ?

Хэрэв та ногдол ашгийн хувьцаанд хөрөнгө оруулах гэж байгаа бол дараах хугацааг анхаарч үзэхийг зөвлөж байна:

**1. IV-V сар:** Зах зээлийн уналтыг ашиглан үнэлгээ нь доогуур байгаа хувьцаануудыг анхааралтай судалж, худалдан авах боломжийг харгалзаж үзэх.

**2. X-XI сар:** Зах зээл идэвхжихээс өмнө хөрөнгө оруулах нь ногдол ашгаас гадна хувьцааны ханшийн өсөлтөөс ашиг хүртэх боломж нэмэгдэнэ.

# ШИЙДВЭР ГАРГАХАД ТАНЬ ТУСАЛЪЯ

Хөрөнгө оруулах компани сонгохын тулд та тухайн компанийн бизнесийн загвар, эрсдэл, өсөх боломж, мөн гол шийдвэр гаргаж буй удирдлагуудын боловсрол, туршлага зэрэг бүхий л мэдээллийг сайтар судалж байж, өөрийн шийдвэрийг гаргах нь зүйтэй.

Таны хөрөнгө оруулалтын шийдвэрийг илүү оновчтой болгоход дэм болох үүднээс компани хэрхэн судлах, мэдээллийг хаанаас олж авах, санхүүгийн тайлан болон гол харьцаа үзүүлэлтийг хэрхэн уншиж ойлгон, шийдвэр гаргалтад хэрхэн ашиглах талаарх зөвлөмжүүдийг хүргэж байна

## ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛТЭЙ ХААНААС, ХЭРХЭН ТАНИЛЦАХ ВЭ?

МХБ-ийн  
вэбсайт  
(mse.mn)

Бүртгэлтэй бүх ХК-иудын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан, хувьцааны ханш зэрэг шийдвэр гаргахад шаардлагатай дийлэнх мэдээлэл МХБ-ийн вэбсайт дээр нээлттэй байдаг.



Энэ QR-г уншуулж, МХБ-д бүртгэлтэй бүх ХК-иудын мэдээллийг авна уу

Компанийн  
өөрийн  
вэбсайт

Шийдвэр гаргахад дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй бол компанийн вэбсайтаас харж болно.

Албан  
ёсны  
медиа  
сүвгууд

Bloomberg Mongolia-с хувьцааны ханшийн мэдээлэл, Lemon Press-ийн и-мэйл товхимолд бүртгүүлснээр ХК-иудын цаг үеийн мэдээллийг хоцролгүй авах боломжтой.

**Жишээлбэл: МХБ-ийн ТОП 20 индекст багтдаг компанийн нэг болох ЛэндМН ББСБ ХК-ийн МХБ-ийн вэбсайт дээрх мэдээлэлтэй танилцаж үзье.**



### 1 Хувьцаатай холбоотой мэдээлэл

Тикер /код/:	LEND
Салбар:	Банк бус санхүү
Сүүлийн ханш:	₮145
<small>(2025.04.04-ний өдрийн байдалээр)</small>	
Ханшийн өөрчлөлт:	+116 (%)
<small>(сүүлийн 1 жил)</small>	
Зах зээлийн үнэлгээ:	₮106.5 тэрбум
Вэбсайт:	lend.mn

### 2 Ерөнхий мэдээлэл

- Хаяг, байршил, тусгай зөвшөөрлийн жагсаалт, хамаарал бүхий компаниудын мэдээлэл

**Гүйцэтгэх удирдлагын мэдээлэл**  
- Гүйцэтгэх захирал  
- ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл  
- Үнэт цаас хариуцсан мэргэжилтний мэдээлэл, холбоо барих дугаар  
**Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид**  
/5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг ХЭ-ийн мэдээлэл/  
**Компанийн хувьд:**  
- Анд Системс ХХК - 81.16%-г эзэмшдэг.

### 3 Санхүүгийн мэдээлэл

Та энэ хэсгээс тухайн компанийн ХК болсоноос хойших бүх **санхүүгийн дэлгэрэнгүй, хураангуй тайлан болон санхүүгийн гол харьцаа үзүүлэлтүүдтэй танилцах боломжтой.**

#### 2024 онд

**Компанийн хувьд:**

**₮79** хүүгийн тэрбум орлого **₮36** цэвэр тэрбум ашиг

**P/E** 1.1

**ROE** 49.5%

**₮15** Нэгж хувьцааны ногдол ашиг

### 4 Үйл ажиллагааны тайлан

Та тухайн компанийн ХК болсоноос хойших бүх **жилийн үйл ажиллагааны тайлан** болон **Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайлантай танилцах боломжтой.**

**Компанийн хувьд:**

Улирал бүр үйл ажиллагааны тайлангаа нийтэлдэг сайн жишигтэй.

### 5 Хурлын мэдээлэл

Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)-ын зар, ХЭХ-ийн шийдвэрүүд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, тогтоолуудтай танилцах боломжтой.

Мөн ногдол ашиг олгох бүртгэлийн өдрийг энэ хэсгээс харах боломжтой.

### 6 Бусад мэдээлэл

ХК-ийн Компанийн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, тухай бүр хүргэх мэдээллийг нээлттэй байршуулдаг.



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ УНШИХ НЬ

## ХЭРХЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН УНШИЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРТЭЭ АШИГЛАХ ВЭ?

Компанийн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан (баланс), орлогын тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон тодруулгаас бүрддэг. Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа орлогын тайлан, баланс, мөнгөн гүйлгээний тайланг анхааралтай уншиж, нарийн үзүүлэлтүүдийг авч үзэх нь чухал.

Жишээ болгон МХБ-д бүртгэлтэй Инновэйшн Инвестмент ХК ийн 2024 болон 2023 оны санхүүгийн тайланг ашиглалаа.

Жишээ компанийн тайланг унших нь:

Орлогын тайлан нь компанийн тайлант хугацаанд хэр хэмжээний орлого олж, зардал гаргаж, ашиг эсвэл алдагдалтай ажилласныг харуулдаг.

Энэхүү тайлан нь компанийн санхүүгийн ашигт ажиллагаа, мөн бизнесийн гүйцэтгэлийг ойлгоход чухал суурь мэдээлэл юм.

### Орлогын тайлан

Тэрбум төгрөгөөр

	23'	24'
1 Борлуулалтын орлого	13.24	26.23
2 Борлуулалтын өртөг	6.04	12.05
3 Нийт ашиг (алдагдал)	7.2	14.18
4 Үйл ажиллагааны бус орлого	1.62	1.68
5 Үйл ажиллагааны зардал	2.43	2.78
6 Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	6.38	13.05
7 Орлогын татварын зардал	0.7	3.0
8 Татварын дараах цэвэр ашиг	5.7	10.03

### 1 3 Борлуулалт ба ашигт ажиллагаа

2024 онд борлуулалт 2 дахин өсөж ₮26.23 тэрбумд, нийт ашиг ₮14.2 тэрбумд хүрсэн нь компанийн орлого, үр ашгийн өсөлт сайн байгааг харуулж байна.

Нийт ашгийн маржин =  $\frac{\text{Нийт ашиг}}{\text{Борлуулалтын орлого}}$

(23') 54%      (24') 54%

3 Нийт ашгийн маржин 2023 болон 2024 онд адил 54% хэвээр хадгалагдсан нь бүтээгдэхүүний өртөг тогтвортой, ашигт ажиллагаа жигд байгааг харуулж байна.

Цэвэр ашгийн маржин =  $\frac{\text{Цэвэр ашиг}}{\text{Борлуулалтын орлого}}$

(23') 43%      (24') 38%

8 Цэвэр ашгийн маржин 2023 онд 43%, 2024 онд 38% болж буурсан ч өндөр түвшинд хадгалагдаж байгаа нь компанийн санхүүгийн тогтвортой байдлыг илтгэнэ.

### 4 5 Зардал ба орлого

- Ерөнхий, удирдлагын болон маркетингийн зардал бага зэрэг өссөн ч, орлогын өсөлттэй харьцуулахад харьцангуй бага байна.
- Санхүүгийн зардал маш бага, бараг өөрчлөгдөөгүй.
- Хүүгийн орлого болон ногдол ашгийн орлого нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтаас үр ашиг хүртэж байгааг илтгэнэ.

Дэлгэрэнгүй тайланд үндэслэн тайлбарыг бичив.





# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ УНШИХ НЬ

ХЭРХЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН УНШИЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРТЭЭ АШИГЛАХ ВЭ?

Жишээ компанийн тайланг унших нь:

Санхүү байдлын тайлан нь компанийн тухайн үеийн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн бүтцийг харуулдаг гол тайлан юм.

Хөрөнгө (эргэлтийн хөрөнгө+эргэлтийн бус хөрөнгө)=Өр төлбөр (богино хугацаат + урт хугацаат) + Эздийн өмч

		Санхүү байдлын тайлан			
Тэрбум төгрөгөөр		23'	24'	23'	24'
<b>1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>17.9</b>	<b>18.7</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	14.0	14.7		
	Бусад	3.9	4.1		
<b>2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>0.9</b>	<b>3.0</b>		
	Үндсэн хөрөнгө	0.6	1.2		
	Биет бус хөрөнгө	0.2	0.5		
	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	1.3		
	Бусад	0.1	-		
<b>3</b>	<b>Нийт хөрөнгө</b>	<b>18.8</b>	<b>21.7</b>		
<b>4</b>	<b>Нийт өр төлбөр</b>	<b>1.3</b>	<b>6.5</b>		
<b>4.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>1.3</b>	<b>6.4</b>		
	Дансны өглөг	0.8	1.4		
	Ногдол ашгийн өглөг	-	3.7		
	Бусад	0.5	1.3		
<b>4.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>0.0</b>	<b>0.1</b>		
<b>5</b>	<b>Эздийн өмч</b>	<b>17.4</b>	<b>15.3</b>		
	Хувь нийлүүлсэн хөрөнгө	4.4	4.3		
	Нэмж төлөгдсөн капитал	4.7	3.6		
	Хуримтлагдсан ашиг	8.4	7.4		
	<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>18.8</b>	<b>21.7</b>		

## 1 Эргэлтийн хөрөнгө

Нэг жилийн дотор мөнгөжих хөрөнгүүд (мөнгө, авлага, бараа материал). Өндөр байх нь богино хугацааны төлбөрийн чадварыг илтгэнэ.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө ₮14.6 тэрбум байгаа нь санхүүгийн нөөц хангалттай харуулж байна.

## 2 Эргэлтийн бус хөрөнгө

Үндсэн хөрөнгө, урт хугацааны хөрөнгө оруулалт зэргийг багтаана. Өсөлт нь урт хугацааны хөгжлийн дохио.

2024 онд ₮3.0 тэрбум болж 3.3 дахин өссөн нь хөрөнгө оруулалт хийснийг харуулна. Та дэлгэрэнгүйг тодруулгаас нь харах боломжтой.

## 3 Нийт хөрөнгө

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн нийлбэр.

2024 онд нийт хөрөнгө ₮21.7 тэрбум болж, өмнөх оноос ₮2.95 тэрбум 15.7%-иар өссөн.

## 4 Өр төлбөр

Компанийн үүрэг хүлээлт. Хэт өндөр байх нь эрсдэл дагуулж болох ч, зөв удирдвал өсөлтийн эх үүсвэр болдог.

Нийт өр ₮6.43 тэрбум болж 5 дахин өссөн нь ногдол ашиг, татварын богино хугацааны өглөгтэй холбоотой. Компани урт хугацааны өр төлбөргүй байна.

## 5 Эздийн өмч

Компанийн эздийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашгийг харуулдаг.

2024 онд ₮15.28 тэрбум болж, ₮2.17 тэрбумаар буурсан нь ногдол ашиг хуваарилж, хуримтлагдсан ашгаас хасагдсан.



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ УНШИХ НЬ

ХЭРХЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН УНШИЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРТЭЭ АШИГЛАХ ВЭ?

Жишээ компанийн тайланг унших нь:

Мөнгөн гүйлгээний тайлан нь компанийн тухайн хугацаанд хэрхэн бэлэн мөнгө олж, зарцуулсныг харуулдаг. Уг тайлангаар дараах гурван чиглэлээр дүгнэлт хийж болно.

## Мөнгөн гүйлгээний тайлан

<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>8.8</b>
	Мөнгөн орлогын дүн	29.3
	Мөнгөн зарлагын дүн	20.5
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-1.6</b>
	Мөнгөн орлогын дүн	2.0
	Мөнгөн зарлагын дүн	3.6
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-6.5</b>
	Мөнгөн орлогын дүн	0.1
	Мөнгөн зарлагын дүн	6.6
	Төлсөн ногдол ашиг	6.6
	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>0.7</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14.0
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>14.7</b>

## 1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгал

Компанийн үндсэн үйл ажиллагаанаас орж ирсэн болон гарсан мөнгөн урсгал.

Эерэг ₮8.8 тэрбум байна. Энэ нь компанийн үндсэн үйл ажиллагаа (бараа, үйлчилгээний орлого гэх мэт) тогтвортой, ашигтай явагдаж байгааг илтгэнэ. Орлого нь зарлагаас давсан нь сайн үзүүлэлт.

## 3 Санхүүжилтийн мөнгөн урсгал

Хувьцаа гаргах, зээл авах, ногдол ашиг тараах зэрэгтэй холбоотой мөнгөн урсгал. Компанийн санхүүжилтийн эх үүсвэрийг харуулна.

₮6.51 тэрбумын сөрөг урсгалтай. Гол шалтгаан нь ногдол ашиг хуваарилалт юм. Компанийн хувьд ногдол ашиг өндөр тараадаг.

## 2 Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал

Хөрөнгө худалдан авах, зарах, хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой мөнгөн урсгал. Ирээдүйн өсөлтөд чиглэсэн хөрөнгө оруулалтын идэвхийг илтгэнэ.

₮1.63 тэрбумын сөрөг урсгалтай байна. Энэ нь компани ирээдүйн өсөлт, өргөтгөлд зориулан хөрөнгө оруулалт идэвхтэй хийж байгааг харуулдаг. Хэдийгээр сөрөг үзүүлэлттэй ч урт хугацаанд эерэг нөлөө үзүүлэх боломжтой.



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ УНШИХ НЬ

ХЭРХЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН УНШИЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРТЭЭ АШИГЛАХ ВЭ?

## ХУВЬЦААНЫ ХАНШИЙГ ҮНЭЛЭХДЭЭ:

$$P/E = \frac{\text{Хувьцааны ханш}}{\text{(Цэвэр ашиг/нийт гаргасан хувьцааны тоо)}}$$

$$P/B = \frac{\text{Хувьцааны ханш}}{\text{(Эздийн өмчийн дүн/нийт гаргасан хувьцааны тоо)}}$$

$$ROE = \frac{\text{Цэвэр ашиг}}{\text{Эздийн өмчийн дүн}}$$

Эздийн 1 төгрөг тутмаас хэдэн хувийн өгөөж олж байгааг илтгэнэ.

## ХЭРХЭН ХОСЛУУЛАН ДҮГНЭХ ВЭ?

ROE	P/E	P/B	Дүгнэлт
Өндөр (>15%)	Бага (<5)	Бага (<1)	Ашигтай, хямд үнэлгээтэй — хөрөнгө оруулахад сонирхолтой
Өндөр (>15%)	Өндөр (>15%)	Өндөр (>1.5)	Өсөлтийн хүлээлттэй ч үнэлгээ өндөр, болгоомжтой хандах
Бага (<10%)	Бага (<5)	Бага (<1)	Зах зээл хямдаар үнэлж байгаа ашиг багатай, эрсдэлтэй
Бага (<10%)	Өндөр (>15)	Өндөр (>1.5)	Хэт өндөр үнэлгээтэй, хөрөнгө оруулагчдын хүлээлттэй зөрж болзошгүй

# ЗОЧИН НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН: Хөрөнгийн зах зээл бол боломж



**Ц.Номин-Эрдэнэ**  
Багш, Санхүү Эдийн  
Засгийн Их Сургууль

Сүүлийн үед “Хөрөнгө оруулалт” гэдэг үг хүн бүхний амны уншлага болж, мэдээ, мэдээлэл ихээхэн тархах болсон. Гэвч үүнийг зөвхөн өндөр орлоготой, санхүүгийн мэргэжилтэй хүмүүс л хийдэг зүйл мэтээр төсөөлдөг хүн цөөнгүй. Үнэндээ хөрөнгө оруулалт бол хүн бүрд нээлттэй бөгөөд зөв ойлгож, бага багаар эхэлбэл санхүүгийн эрх чөлөөнд хүрэх бодит боломж юм. Гэтэл бидний ихэнх нь өнөөг хүртэл хадгаламж гэдэг бүтээгдэхүүнийг л ашигласаар байна. Үнэхээр ч хадгаламж нь багагүй давуу талтай. Эрсдэл багатай, мөнгөө хүссэн үедээ авах, хадгаламж барьцаалан зээл гэх мэт. Гэвч төгрөгийн худалдан авах чадвар жилээс жилд буурч буй энэ үед хадгаламжийн бодит өгөөж бараг л алдагдалтай тэнцэж, таны хүүгийн орлого өнөөдөр үнэ цэнээ хамгаалж чадахаа больжээ.

**Тэгвэл хөрөнгө оруулалт гэж юу вэ?** Хөрөнгө оруулалт нь та орлогоосоо тодорхой хэсгийг ирээдүйд илүү их үнэ цэнэ бүтээх зорилгоор аливаа санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах үйл явц бөгөөд үүний нэгэн жишээ нь хувьцаа юм. 2022 онд “Meta” компанийн хувьцаа нэгж нь ердөө 90 ам.доллар болж, 2021 оны оргил үедээ хүрсэн 380 ам.доллараас 76% унав. Тухайн үед “Facebook хэж байна”, “Meta-ийн үе дууссан” гэх мэтээр хэт их сэтгэл хөдлөлд автсан тайлбарууд хийж, олон хөрөнгө оруулагчид хувьцаагаа айж зарсан байдаг. Гэвч зах зээлийн уналт бүрийн цаана макро эдийн засгийн суурь шалтгаан, эргээд өсөх боломжууд байдаг.

Хэрэв макро эдийн засгийн нөхцөл байдлыг зөв уншсан бол энэхүү уналтыг боломж болгон харж, ихээхэн ашиг олох боломжтой байсан буюу АНУ-ын Холбооны Нөөцийн Сангийн хүүгийн түвшингийн өөрчлөлт зарим технологийн компаниудын хувьд томоохон боломж болж, 2024 оны эхэн үед Meta-ийн хувьцаа нэгж нь 740 ам.доллат хүрч, 2022 оны уналтаас бараг 700%-иар өссөн юм. Тус жишээ нь та заавал хямд үнээр хувьцааг аваад, хамгийн өндөр дүн дээр зар гэсэн үг биш бөгөөд үүний цаана эрсдэл ч мөн байдаг гэдгийг ойлгох хэрэгтэй. Үүнийг л судалж, тайлбарлахын тулд энэ салбарт шинжээчид гэдэг хүмүүс байдаг. Ялангуяа сүүлийн жилүүдэд Монголд ҮЦК-иуд эрчимтэй хөгжиж, энэ талаар мэдээлэлтэй хүмүүс олширч, хөрөнгө оруулалтын салбар маш сонирхолтой болсоор байна.

**Хөрөнгийн зах зээл хангалттай том болчихсон, ашиг олоход хэцүү биш гэж үү?** Тус асуулт шинээр хөрөнгө оруулагчдад ихээхэн тулгардаг. Сүүлийн 10 гаруй жилд ХЗЗ-ийн үнэлгээ ойролцоогоор 8 дахин өссөн ба тус өсөлтийг “Хангалттай өсчихсөн юм чинь ирээдүйд унана” гэх хүмүүс олон. 1984 онд дэлхийн хувьцааны зах зээлийн нийт үнэлгээ 2.4 их наяд ам.доллар байсан ба өнөөдөр буюу 40 жилийн дараа энэхүү үнэлгээ 115 их наяд ам.долларт хүржээ. Улс орон бүрийн эдийн засгийн хөгжил, макро эдийн засгийн бодлогоос хамааран харилцан адилгүй байх боловч энэхүү хөрөнгийн зах зээл гэдэг ойлголт нь зөв сонголтын ард хязгааргүй их өгөөж нуугдаж буйг илтгэнэ.

**Тэгвэл хэрхэн зөв эхлэх вэ?** Хөрөнгө оруулалтын ертөнцөд хөл тавих гэж буй хүн бүрийн хувьд хамгийн чухал зүйл бол эхний алхмаа зөв тавих явдал юм.

Энэ бол сэтгэл зүйн бэлтгэл, зорилго, мэдлэгт суурилсан сонголтын тухай ойлголт юм. Юуны өмнө, та өөрөөсөө “Би юунд хүрэхийг хүсэж байна вэ? Хүүхдийнхээ ирээдүйн боловсрол уу?, амралт зугаалгын сан уу?, эсвэл тэтгэврийн санхүүгийн бие даасан байдал уу?”. Зорилгоо тодорхойлсон мөчөөс эхлэн таны хөрөнгө оруулалт зүг чигтэй болно. Учир нь зорилго бүр өөр стратеги шаарддаг. Зарим нь урт хугацаанд тэвчээр шаардана, зарим нь илүү хурдан эргэлт, ашиг хүлээнэ.

Дараагийн чухал зүйл бол эрсдэлийг хүлээн зөвшөөрөх чадвар. Хөрөнгийн зах зээл хэзээ ч шулуун замаар өсдөггүй ба зах зээл үргэлж хэлбэлзэж, заримдаа унах ба энэ нь төгсгөл бус, харин лугшиж буй амьд организм мэт байгалийн жам. Ихэнх шинэ хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө оруулалтыг судалгаагүйгээр шууд л эхэлдэг ба ихэвчлэн зах зээлд таагүй байдал үүсэж байгаа үед эхлэх нь олонтаа. Тийм учраас тодорхой хэмжээний макро орчны судалгааг заавал хийх шаардлагатай.

Бидний хувьд хөрөнгө оруулалт нь дэндүү шинэ мэт боловч дэлхий дахинд хөгжлийн дээд түвшинд хүрч, хэдийнээ 400 гаруй жилийг үдсэн салбар юм. Нэгэн оюутан ахуйн найз маань өвлөж авсан *Johnson and Johnson (JNJ)*-ний хувьцааны 5 хүрэхгүй хувийг борлуулж машин худалдан авч байсныг харж байлаа. Энэ нь тэдний хувьд хэдийн амьдралынх нь нэг хэсэг болсон гэдэг нь надад маш ихээр атаархал төрүүлж байв. Тиймээс ч миний хувьд утга учиртай хөрөнгө оруулагчдыг бүтээж, чадлынхаа хэрээр мэдлэг, мэдээлэл түгээхийн тулд өөрийн ажил, мэргэжлээ тус салбарт сонгосон. “Дундаж хөрөнгө оруулагчид төгөлдөржсөн цагт улс орны эдийн засаг хөгжинэ” хэмээн хөрөнгө оруулалтын ертөнцөд домог болсон Питер Линч зүгээр ч нэг хэлээгүй гэдэгт итгэдэг.

# ХЗЗ-ийн мэргэжилтнүүд зөвлөж байна



**Т.Энх-Амгалан**

Арилжаа, судалгааны  
газрын захирал  
**АПЕКС КАПИТАЛ ҮЦК**

Брокерын компаниа зөв сонгох нь яагаад чухал вэ?

Арилжаанд оролцоход хамгийн чухал зүйлүүдийн нэг бол брокерын компаниа зөв сонгох асуудал байдаг. Мэргэжлийн чадварлаг брокерын компани нь танд зах зээлийн чухал мэдээ мэдээллүүдийг цаг алдалгүй хүргэх бөгөөд мэргэжлийн судалгаа шинжилгээгээр хангаж таны хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад туслалцаа үзүүлэх юм.

Мөн мэдээлэл болон судалгаагаар хангахаас гадна таны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, стратеги зэргийг зөв гаргахад бодитой зөвлөгөө мэдээллийг өгөх болно.

Апекс Капитал ҮЦК-ийн хамт олон нь танд хөрөнгө оруулалтын мэргэжлийн зөвлөгөө үзүүлэхээс гадна танд тохирсон хөрөнгө оруулалтын багцыг хамтдаа бүрдүүлж өгөх юм.



**М.Тэмүүлэн**

Хөрөнгө оруулалтын ахлах  
зөвлөх  
**АПЕКС КАПИТАЛ ҮЦК**

Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа санхүүгийн тайлангаа гадна дараах 3 хүчин зүйлсийг харгалзан шийдвэрээ гаргаарай.

**1. Арилжааны идэвх:** Авсан хувьцаа 100% өссөн ч тухайн хувьцааг худалдан авах захиалга байхгүй бол ашгаа хэрэгжүүлэх боломжгүй. Иймд хувьцааны өдрийн арилжааны идэвх, эрэлт хэр их байгаа шалгах нь чухал юм.

**2. Ашгийн таамаг:** Хувьцаа эзэмшигчдийн хурал болон үйл ажиллагааны тайлангаа танилцуулах үед дараа жилийн орлогын төсөөллөө ХК-ууд танилцуулдаг. Өнгөрсөн оны тайлангаас үйл ажиллагааны төсөөлөлдөө хүрч чадсан эсэхийг шалгах хэрэгтэй.

**3. Өрсөлдөгчийн судалгаа:** ижил төстэй үйл ажиллагаа эрхэлж буй компаниуд болон тухайн салбарын судалгаатай танилцаж, харьцуулан тухайн компанийн байр суурийг тодорхойлох боломжтой.



**Л.Дуламхүү**

Арилжааны ахлах брокер  
**ГҮҮДСЕК ҮЦК**

## Хөрөнгийн зах зээлийн шинэхэн оролцогчдод

Үнэт цаасны арилжаанд оролцоход шаардагдах суурь мөнгөн дүн гэж байдаггүй. Та 20,000 төгрөгөөр 2 хувьцаа авч болно, 200 хувьцаа ч авч болно. Арилжаанд оролцох дүнгээ та өөрийн санхүүгийн байдалд дарамт учруулахгүйгээр сонгох нь чухал. Бага дүнгээр давтамжтай хөрөнгө оруулалт хийж хувьцааны хуримтлал үүсгэх нь зүйтэй.


Та өөрийн хуримтлалаа үүсгэхдээ зөвхөн нэг компанийн хувьцаа авах биш өөр өөр салбарт үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн компанийн хувьцааг худалдан авснаар ханшийн зөрүүнээс үүдэн гарах эрсдэлийг бууруулах боломжтой.





# АРИЛЖААГАА АПЕКСААР

## АРЕХ TRADERS 2.0



АРЕХ TRADERS АПП ТАТАХ



Android



iOS



ДОТООД  
ХУВЬЦАА



БОНДЫН  
АРИЛЖАА



ГАДААД  
ХУВЬЦАА



ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН  
ЗӨВЛӨХ

☎ 7510-7500

✉ investment@apex.mn

# ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД “IR” ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Investor Relations (IR) буюу хөрөнгө оруулагчидтай харилцах үйл ажиллагаа нь компани болон түүний хувьцаа эзэмшигч, боломжит хөрөнгө оруулагчид болон бусад ХЗЗ-ийн оролцогч талуудын хооронд үр дүнтэй харилцааг бий болгож, хадгалахад чиглэсэн стратегийн удирдлагын чиг үүрэг юм. ХК-иуд IR-аа сайн хөгжүүлснээр хөрөнгө оруулагчдын хувьд тухайн ХК-тай холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй, анхдагч эх сурвалжаас авах боломжтой болж, баримт дээр суурилсан оновчтой хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх, цаашид ХЗЗ дэх мэдээллийн урсгал илүү үр ашигтай болох ач холбогдолтой.

**IR хөрөнгө оруулагчдын талаас:** Хөрөнгө оруулах гэж буй болон хөрөнгө оруулсан компани ТАНИХ нь хөрөнгө оруулалтын шатны хамгийн чухал хэсэг бөгөөд IR нь хөрөнгө оруулагчдад тэрхүү үе шатыг хялбар болгож, түүний дагуу компанийн тухай мэдээллийг ил тод, хүртээмжтэй хүргэх үүргийг IR нэгж гүйцэтгэдэг.

**Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт ба IR:** IR нь хөрөнгө оруулагчдад компанийн санхүү, бизнес модел, үйл ажиллагааны мэдээлэл, хэрэгжүүлж буй стратеги, эрсдэл, өсөлтийн боломжуудыг ойлгоход тусалдаг, бөгөөд эдгээр мэдээлэл нь цаашлаад хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулах шийдвэрээ гаргах, амжилттай хөрөнгө оруулахад нь дэмжлэг болдог.

**“Сайн” IR:** Хөрөнгө оруулагчидтайгаа сайн харилцдаг компани гэдэг нь хөрөнгө оруулагчид, олон нийтэд зөвхөн журмын дагуу мэдээлэл (санхүү, үйл ажиллагааны тайлан гэх мэт) хүргэхээс гадна компанийн тухай бүхий л төрлийн мэдээллийг ил тод, тогтмол, тасралтгүй, үнэн зөвөөр мэдээлдэг компанийг хэлнэ.



## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД IR ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?

### 1 Анхдагч эх сурвалж

ХК-ийн IR нэгж нь хөрөнгө оруулагчдад чухал, шаардлагатай мэдээ мэдээллийг цаг тухайд нь, үнэн бодитоор авах боломжийг бүрдүүлж өгдөг.

### 2 Шууд Харилцах Боломж

IR нэгж нь ХК-ийн хөрөнгө оруулагчдад холбоотой харилцааг хариуцдаг учир ХК-тай холбоотой асуултууд асуух, мэдээлэл тодруулга авах боломжтой болдог ба тухайн компанийг илүү цогц байдлаар үнэлж дүгнэхэд

### 3 Шийдвэр гаргалт сайжрах

IR нэгж нь менежментийн багийн удирдлагын арга барил, гүйцэтгэл болон компанийн засаглалтай холбоотой хэрэгжүүлж буй ажлуудыг хөрөнгө оруулагчдад ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэдэг.

### 4 Менежментийн баг, компанийн засаглалыг ойлгох

IR нэгж нь хөрөнгө оруулагчдад үйл ажиллаганы тайлан, Хувьцаа Эзэмшигчдийн Хурал дээр яригдсан төвөгтэй мэдээлэл болон компанийн онцлогийг ойлгомжтой байдлаар тайлбарлаж хүргэдэг ба хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад хэрэгтэй бүхий л мэдээллийг өгдөг.

### 5 Зах зээлийн хүлээлт, хөрвөх чадвар

IR нэгж нь ХК-иас хүлээх хүлээлтийг илүү ойлгомжтой болгож өгдөг бөгөөд компанийн хэрэгжүүлж буй стратеги, үйл ажиллагааг ойлгомжтой хүргэж мэдээллийн зөрүүтэй байдлаас үүсэх хувьцааны ханшийн савалгааг багасгаж, хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлдэг.

# ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА

## Тайлангийн хурал (Earnings Call)

Олон улсад Earnings call-г мэргэжлийн шинжээчдийн хүрээнд зохион байгуулдаг. Энэ нь шинжээчдээр дамжуулан хөрөнгө оруулагчдыг оновчтой шийдвэр гаргахад тусалж, компанийн ил тод байдлыг нэмэгдүүлдэг.

Монголын зарим ХК-иудын зохион байгуулсан Earnings Call-ыг энэхүү QR-ыг уншуулан, үзнэ үү.



## Шинжээчдийн болон Хөрөнгө Оруулагчдын Өдөрлөг

Шинжээчид болон Хөрөнгө Оруулагчдын Өдөрлөг нь бол хувьцаат компаниуд санхүүгийн гүйцэтгэл, бизнесийн стратеги, ирээдүйн төлөвлөгөөг зэргээ хөрөнгө оруулагчид, шинжээчдэд танилцуулдаг арга хэмжээ юм. Тус арга хэмжээ нь хөрөнгө оруулагчдад компанийн ирээдүйн төлөвийг ойлгох, сонирхсон асуултаа шууд асуух, хариулт авах боломжийг олгодог.

## Хөрөнгө оруулагчдын хандлагын судалгаа

Жижиг хувьцаа эзэмшигчид болон томоохон хөрөнгө оруулагч, мэргэжлийн шинжээчдийн зүгээс тухайн компанийг хэрхэн дүгнэж байгааг хөндлөнгөөс судлан гаргасан хөрөнгө оруулагчдын хандлагын судалгаа юм. Тус арга барил нь IR-г сайжруулах чухал хэрэгсэл болдог, бөгөөд судалгааны үр дүнд үндэслэн зах зээлийн хандлага болон шийдэх асуудлыг тодорхойлон үйл ажиллагаанд нэвтрүүлж, цаашид хэрэгжүүлэх стратегийг боловсруулдаг.

## IR Календарь

Нээлттэй хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигчид болон бусад хөрөнгө оруулагч, ҮЦК-ийн шинжээч зэрэг хөрөнгийн зах зээлийн оролцогч талуудад СЗХ, МХБ-ийн журмын хүрээнд заавал мэдээлэх мэдээллүүдээс гадна компанийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд болон салбарт гарч буй өөрчлөлтүүд зэрэг бусад шаардлагатай мэдээллийг тасралтгүй үр дүнтэй хүргэхэд зориулсан төлөвлөгөө юм.

## Удирдлагын хэлэлцүүлэг ба шинжилгээ

Management's Discussion & Analysis (MD&A) буюу удирдлагын хэлэлцүүлэг, шинжилгээ нь удирдлагын багийн бизнесийн гүйцэтгэл, санхүүгийн үр дүн, эрсдэл, ирээдүйн төлөвийг тайлбарладаг санхүү болон үйл ажиллагааны тайлангийн нэгэн хэсэг юм. MD&A нь хөрөнгө оруулагчид болон санхүүгийн шинжээчдэд компанийн бодлого, үйл ажиллагааны үр нөлөөг ойлгоход тусалдаг.

## Хөрөнгө оруулагчидтай харилцах стратеги

Одоо буй хувьцаа эзэмшигчид болон бусад хөрөнгө оруулагч, ҮЦК-ийн шинжээчид гэх мэт хөрөнгийн зах зээлийн оролцогчидтой үр дүнтэй харилцахад ХК-ийн IR стратегийг оновчтой тодорхойлох хэрэгтэй. IR стратегийг оновчтой тодорхойлох нь компанийн нэр хүндийг өсгөх, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.



# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ “IR”-ИЙН САЙН ТУРШЛАГА

## Q4, 2024 EARNINGS CALL:




2024 оны үйл ажиллагааны үр дүнгээ хөрөнгө оруулагчдад онлайнгаар танилцуулж, мэргэжлийн шинжээчдийн асуултад хариулав.

## УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ:



2024 оны санхүүгийн тайлан гүйцэтгэлийн үзүүлэлтийг менежментийн зүгээс тайлбарлаж олон улсын сайн туршлагын дагуу тайлан гаргав.

## 2025 КАЛЕНДАРЬ:



2025 онд хөрөнгө оруулагчид руу чиглэсэн үйл ажиллагаа, гаргах тайлангийн календарьчилсан төлөвлөгөөг олон нийтэд танилцуулав.

## БОРКШОП:



Хөрөнгө оруулагчтай харилцах чиглээр мэргэжлийн байгуулаагаас менежментийн багийн хүрээнд сургалт авав.

## 2024 оны Голomt Банк Earnings Call үзэх



## Голomt Банк MD&A унших



## Голomt Банк IR Календарь танилцах



## Голomt Банк CEO Letter унших



## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ:



Голomt Банкны Гүйцэтгэх захирал 2024 оны ажлуудаа дүгнэж, банкны цаашдын алсын хараа, стратегийг хувьцаа эзэмшигчдэдээ хүргэв.

## ШИНЖЭЭЧДИЙН ӨДӨР:



ҮЦК болон ХОМК, сангийн мэргэжлийн шинжээчидтэй уулзалт хийж банкны стратеги, цаашдын төлөвлөгөөг танилцуулж, асуултад хариулав.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН УУЛЗАЛТ:



Хувьцаа эзэмшигчидтэй тусгайлсан цуврал уулзалтуудыг хийж, цаашдын стратегийг танилцуулан, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулав.

## 2025 СТРАТЕГИ:

**Хөрөнгө оруулагчдын харилцааг бэхжүүлэх, олон улсын стандартыг мөрдөн ажиллахаар тодорхойлов.**

# • Холбоо барих

Өмнөх дугааруудтай  
танилцах бол

Email: [info@capitalmarkets.mn](mailto:info@capitalmarkets.mn)  
Website: [capitalmarkets.mn](http://capitalmarkets.mn)  
Phone: 99210566

